



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/21

Ховд

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний эрхийн төлөв байдлын тайланг хангалтгүй тайлагнасан тул Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Чулуукаагийн Эрдэнэбатад “ганцаарчилсан хэлбэрээр сануулах” сахилгын шийтгэл ногдуулсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.
3. Албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргээ хангалттай биелүүлж, үүрэг хариуцлага, ажлын үр дүнгээ сайжруулан холбогдох хууль, тогтоомжуудыг мөрдөн ажиллахыг Ч.Эрдэнэбатад үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Н.Ганзориг)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.САНДАГСҮРЭН